

Хөгжмийн багшийн түүвэрт сонгогдсон хүүхдийн гүйцэтгэх даалгавар-багшид

Даалгаврын дугаар: 1		Бүлэг: Ахлах	
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим	
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II		Танин мэдэхүйн түвшин: Хэрэглэх	
Илрүүлэх чадвар: Өөрийн мэддэг дуу болон хөгжмийн аялгууг сонсоод таних, нэрлэх, тохирох хөдөлгөөн хийх.		Интеграци эсэх: Үгүй	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай	
Даалгавар	“Энэ ямар дууны ая вэ?” таагаарай.		
Хэрэглэгдэхүүн	Багшийн өмнө нь заасан буюу хүүхдийн мэддэг дууны аяыг ашиглана.		
Даалгаврын заавар	Аялгууг сонсоод ямар дууны ая болохыг хэлээрэй. Дууны аянд тохируулан хөдөлгөөн хийнэ.		
Даалгаврыг явуулах аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>		<i>Багшийн хийх үйлдэл</i>
	Багш нь нэг дууны ая сонсгоно анхааралтай сонсоорой. Ямар нэртэй дууны ая байна вэ? Дууны аяыг сонсоод дуртай хөдөлгөөнөө хийгээрэй.		Дууны аяыг 1 удаа сонсгоно.
Дэмжлэг	Шаардлагатай үед харилцан ярилцаж, дөхүүлсэн асуултыг тавина. Хүүхэд эргэлзэх болон тогтож сонсохгүй байгаа тохиолдолд дууны бичлэгийг дахин сонгож асуултыг дахин хэлж өгнө.		
Анхаарах зүйл	Хэмнэлийн хувьд эрс ялгаатай хурдан, удаан хөгжмийн ая болон дуунаас сонгоно.		

Даалгаврын дугаар: 2		Бүлэг: Ахлах	
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим	
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II		Танин мэдэхүйн түвшин: Задлан шинжлэх	
Илрүүлэх чадвар: :Дууны эхлэл, дахилтыг сонсож ялгаж дуулна.		Интеграци эсэх: Үгүй	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай	
Даалгавар	“Бид дуучин”		
Хэрэглэгдэхүүн	Дууны бичлэг, хөгжим		
Даалгаврын заавар	Хүүхдийн дуулсан хоолойтой дууны бичлэгийг сонсоод дууны эхлэл, дахилтыг сонсож дуулна..		
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
	<ul style="list-style-type: none"> - Багш нь нэг дуу дуулж сонсоё. Сонсоорой. - Багшийгаа дуулж байгааг анхааралтай ажиглаарай. - Дуун дээр юуны тухай гарж байна вэ? - Багштайгаа хамтдаа дуугаа дуулья. 		Хүүхдэд дууг нэг удаа сонсоно. Дараагын удаа дууг эхлүүлж хүүхдийг дууны эхлэх болон дахилтыг нь дуулахыг санал болгоно. Хүүхэд дууны аялгуу, хэмнэл зөв, өнгө алдахгүй дуулж байгаа эсэхийг ажиглаж тэмдэглэнэ.
Дэмжлэг	Дууны эхлэл, төгсгөлийг хүүхдэд хэлэхгүй. Хүүхэд өөрийнхөөрөө чөлөөтэй байх орчныг бүрдүүлсэн байна. Даалгаврыг ойлгоогүй хүүхдэд дахин тайлбарлаж өгнө. Хүүхэд дуулахгүй байгаа тохиолдолд дахин удаа дууг сонгох/дуулж дэмлэг үзүүлээрэй.		
Анхаарах зүйл	Видео бичлэгтэй ашиглахгүй зөвхөн аудио бичлэгийг сонсоно. Дууны эхлэл, дахилтын хэсгийг хүүхдэд хэлэхгүй. Дууны бичлэг байхгүй тохиолдолд багш дуулж болно. Хөгжмийн багшийн заасан дууны жагсаалтаас дууг сонгох тохиолдол зөвхөн үнэлгээний баг, гишүүд дууг сонгоно.		

Даалгаврын дугаар: 3		Бүлэг: Ахлах	
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим	
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II		Танин мэдэхүйн түвшин: Сэргээн санах	
Илрүүлэх чадвар: Мэддэг дууныхаа хэмнэлийг бусадтай хамтран энгийн хөгжмийн зэмсгээр тоглоно.		Интеграци эсэх: Үгүй	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай	
Даалгавар	“Хэмнэлээр наадъя”		
Хэрэглэгдэхүүн	Багшийн өмнө заасан хүүхдийн мэддэг дуу, бөмбөр, дуут мод, шагшуур, кастенет		
Даалгаврын заавар	Багш ширээн дээр хөгжмийн зэмсгүүдийг байрлуулна. Дууг тоглуулж хүүхдэд сонсгож ярилцана. Дууны хэмнэлийг хүүхэд хөгжмийн зэмсэгээр тоглоно.		
Даалгаврыг явуулах аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>		<i>Багшийн хийх үйлдэл</i>
	-Багш нэг дуу сонсоё. Анхааралтай сонсоорой. -Ямар дуу сонссон бэ? Багшийнх нь заасан, чиний мэддэг дуу нь мөн үү? -Нэг хөгжмийн зэмсгийг сонгож аваарай. -Өөрийн сонгож авсан хөгжмийн хөгжмийн зэмсгийг нэрлээрэй. -Багш нь дууг дахин эхлүүлнэ. Хөгжмийн хэмнэлийг дагаж хөгжимдөөрэй.		Шаардлагатай тохиолдолд бичлэгийг дахин 1 удаа эхнээс тоглуулж болно. Багш даалгаврыг эхлүүлэхийн хэмнэлийн дагуу хэрхэн хөгжимдөхийг нэг удаа биечлэн хийж үзүүлнэ. Хүүхэд дууны хэмнэлийг зөв, тоглож байгаа эсэхийг ажиглаж тэмдэглэнэ.
Дэмжлэг	Хүүхэд эргэлзэх болон тогтож сонсохгүй байгаа тохиолдолд бичлэгийг дахин сонсгож асуултыг дахин хэлж өгнө. Чадахгүй эргэлзэж байгаа тохиолдолд багш хамтдаа 1 удаа тоглоорой.		
Анхаарах зүйл	Багшийн өмнө нь заасан, хүүхдийн мэддэг дууг сонгож авна. Цэцэрлэг болон бүлэгт байгаа сургалтад ашигладаг хөгжмийн зэмсгээс сонгоно. Үйлдлийг хийхэд яаруулахгүй байна.		

Даалгаврын дугаар: 4		Бүлэг: Ахлах бүлэг
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II		Танин мэдэхүйн түвшин: Ойлгох
Илрүүлэх чадвар: Дүрс бичлэг үзэж бүжгийн хөдөлгөөнийг дуурайж хийнэ.		Интеграци эсэх: Үгүй
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай
Даалгавар	Хамтдаа бүжиглэе.	
Хэрэглэгдэхүүн	“Хэрвээ сайхан амьдарч байвал” бүжгийн бичлэг: https://www.youtube.com/watch?v=UpS-4OLzrm4	
Даалгаврын заавар	Хүүхдэд бичлэгийг үзүүлж хөдөлгөөнийг ярилцаж багш хүүхэд нэг удаа хамтдаа хийсний дараа хүүхэд хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөнийг бие даан хийнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	-Бүжгийн бичлэгийг анхааралтай үзээд ямар хөдөлгөөн хийж байгаа, энэ хөдөлгөөнөөр юуг илэрхийлж байгаа болохыг хэлээрэй. -Багш нь бүжгийн бичлэгийг дахин эхлүүлнэ. -Бүжгийн хөдөлгөөнийг дагаж бүжиглээрэй.	Бүжгийн бичлэгийг тоглуулна. Хүүхэдтэй ярилцан бүжгийн хөдөлгөөнийг хамтдаа нэг удаа хийнэ.
Дэмжлэг	Хүүхэд даалгаврыг гүйцэтгэхийн өмнө бүжгийн хөдөлгөөнийг ойлгоогүй болон анхаарал сарнисан тохиолдолд бүжгийн бичлэгийг нэг удаа үзүүлж тайлбарлана. Хүүхэд бүжгийн хөдөлгөөнийг хийж байхдаа зогсолт хийсэн бол багш хөдөлгөөнийг үргэлжлүүлэн дагуулан хийнэ.	
Анхаарах зүйл	Бүжгийн утга санааг хүүхдэд шууд хэлэхгүй, хүүхэд бүжиглэх явцдаа хөдөлгөөнийг хийхгүй зогссон бол багш хөдөлгөөнийг үргэлжлүүлэн дагуулан хийж болох ч дуустал дагуулан хийхгүй.	